



Чулуутын багш ХХК - авч үзсэн

БУЛГАН АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР  
УЛСЫН БАЙЦААГЧИЙН  
ДҮГНЭЛТ

“ЧУЛУУТЫН БАГШ” ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ Ж.МӨНХ-ОЧИР ТАНАА

Чин Ван Ханддоржийн өргөн чөлөө 1-103  
Булган баг, Булган сум, Булган аймаг, 63086  
Утас: 7034-2455

E-mail: Bulganemg@bu.mohs.gov.mn  
Website: www.Bu.mohs.mn

2024.02.16 № 10-17-02/077/04

Танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_ т

Зураг төсөлд эрүүл ахуйн хяналт  
хийсэн тухай

Танай компаниас 10 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 5.1.2 дахь заалт, ЭМЯ-ны Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/02 дугаар бүхий “Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, ашиглалтад оруулахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийх тухай” удирдамжийн хүрээнд ажлын зургийг 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдөр Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Д.Ариунаа хүлээн авч, эрүүл ахуйн хяналт хийлээ.

**Нэг. Барилга байгууламжийн нэр, байршил, зориулалт:**

Булган аймгийн Баяннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн өргөтгөлийн барилга /120 суудалтай/

**Хоёр. Захиалагчийн нэр, хөрөнгө оруулалт, хийгдэх ажил:**

Булган аймгийн Баяннуур сумын ЗДТГ

**Гурав: Барилга байгууламжийн зураг төсөл хийсэн зургийн байгууллага:**

Барилгын иж бүрэн ажлын зургийг “ЧУЛУУТЫН БАГШ” ХХК-д /ЗТ11-283/21/ боловсруулсан; ЕГ ШИФР: ЧБ-03/2023

**Дөрөв: Инженер геологийн судалгааны талаар:** “ХАНГАЙ ИНЖ ГЕО” ХХК хийж, гүйцэтгэсэн. Архив: 75/23 ЗТ11-910/21. Өрөмдлөгийн 9 метрийн гүнтэй 2 цооногийн 3.5-3.6 метрт ус илэрсэн, устай үйлчлэлд орохдоо овойлт үүсгэхгүй хөрсний төрөлд багтана.

**Тав. Барилга байгууламжийн зураг төслийн бүрдэл, товч агуулга:**

ГХБХБГ-ын 2023.10.08-ны өдрийн АТД-28/2023 дугаартай 17 заалт бүхий архитектур төлөвлөлтийн даалгавартай.

Сургуулийн эдэлбэр газрын хэмжээ 14227 м<sup>2</sup> /газар эзэмших гэрчилгээний дугаар 000000483, нэгж талбарын дугаар 6301000224/, Баяннуур сумын Засаг

632305051

даргын 2024 оны 01 сарын 05 ны өдрийн А/01 дугаар захирамжаар 3747 м<sup>2</sup> нэмж олгосон. Газар эзэмших гэрчилгээний дугаар 0000246348, нэгж талбарын дугаар 6301001046.

Гадна орчинд авто болон явган хүний зам /хөтөч хавтанцар замтай/, ногоон байгууламж, цугларах талбай, бохирын цооног, хашаа төлөвлөгдсөн.

Барилга нь тэнхлэгээрээ 15.5 м х 24 м хэмжээтэй 2 давхар 1 блок барилга, үндсэн барилгатай 7.6 м х 3.5 м хэмжээтэй 1 давхар хүзүүвчээр холбогдоно. Нийт 120 сурагч хүлээн авах хүчин чадалтай, анги дүүргэлтийг 24 сурагчаар тооцсон.

**I давхарт:** 1 дүгээр анги-67.60 м<sup>2</sup>, тоглох болон ариун цэврийн зангилаа хэсэгтэй, 2-5 дугаар анги-67.20 м<sup>2</sup>, сурагчдын эмэгтэй ариун цэврийн өрөө-12.52 м<sup>2</sup> /2 угаалтуур, 2 суултууртай/, эрэгтэй ариун цэврийн өрөө-12.52 м<sup>2</sup> /2 угаалтуур, 2 суултуур, 1 шээлтүүртэй/, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан-ариун цэврийн өрөө-4.38 м<sup>2</sup>, багшийн хөгжлийн өрөө-33.44 м<sup>2</sup>, хонгил, хүзүүвч, шатны хонгил, цахилгаан, дулааны узель;

**II давхарт:** Анги-68.40 м<sup>2</sup>, анги-68.60 м<sup>2</sup>, анги-68.20 м<sup>2</sup>, сурагчдын эмэгтэй ариун цэврийн өрөө-12.52 м<sup>2</sup> /2 угаалтуур, 2 суултууртай/, эрэгтэй ариун цэврийн өрөө-12.52 м<sup>2</sup> /2 угаалтуур, 2 суултуур, 1 шээлтүүртэй/, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан-ариун цэврийн өрөө-4.38 м<sup>2</sup>, агуулахын өрөө-12.45 м<sup>2</sup>, хонгил, шатны хонгил төлөвлөгдсөн;

Захиалагчийн хүсэлтээр өргөтгөлийн барилгын хүзүүвчээр холбогдсон хэсэгт сургуулийн үндсэн барилгын анги танхимыг өдөр өнжүүлэх болон сургалтын зориулалтаар ашиглана. Үүнд: 1 дүгээр ангийн эрэгтэй өдөр өнжүүлэх бүлэг-49.25 м<sup>2</sup>, 1 дүгээр ангийн эмэгтэй өдөр өнжүүлэх бүлэг-49.25 м<sup>2</sup>, 2-5 дугаар ангийн эрэгтэй өдөр өнжүүлэх бүлэг-63.50 м<sup>2</sup>, 2-5 дугаар ангийн эмэгтэй өдөр өнжүүлэх бүлэг-50.02 м<sup>2</sup> өрөөнүүдтэй.

**Барилгын байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг, цахилгаан хангамж:**

Анги танхимын гэрэлтүүлгийн коэффициентийн цонхны талбайг шалны талбайд харьцуулсан харьцаа 1:4, зохиомол гэрэлтүүлгийг өрөөнүүдийн онцлогт уялдуулсан;

**Агааржуулалт, агааржуулалтын систем:** Барилгын агааржуулалтын системийг механик болон ердийн систем хосолсон байхаар төлөвлөсөн. Хичээлийн танхим ердийн сорох системтэй;

**Барилгын цэвэр, бохир ус хангамж, дулаан хангамж:**

Дулаан хангамж: Булган аймгийн "Баян нутгийн илч" ХХК-ийн техникийн нөхцөлөөр төвлөрсөн дулааны шугамнаас холбоно.

Цэвэр усан хангамж: Сургуулийн эзэмшлийн гүн өрмийн худгаас хангагдана.

Бохир усан хангамж: Шинээр хийгдэх 40 м<sup>3</sup> багтаамжтай соруулах цооногт

холбогдоно. Цооног нь барилгаас 30 м-ээс доошгүй зайд төлөвлөгдсөн.

**Зургаа.** Эрүүл ахуйн тухай хуулийн 5.3 дахь заалтыг үндэслэн **ДҮГНЭХ НЬ:**

“Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт” БНБД 31-25-22-д нийцэж байгаа тул эрүүл ахуйн талаас татгалзах зүйлгүй болно.

Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл “Төрийн хяналт шалгалтын тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу дээд шатны албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН  
ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ



Д.АРИУНАА

ХҮЛЭЭН АВСАН:

КОМПАНИЙН ЗАХИРАЛ

Ж.МӨНХ-ОЧИР

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний тайлбар.....

.....

Улсын байцаагчийн тайлбар.....

.....